

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

| | |
|---|----|
| 1. Аудитын гэрчилгээ | 2 |
| 2. Аудитын тайлан..... | 4 |
| 2.1. Оршил | 4 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 4 |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 4 |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 4 |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 5 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 5 |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 5 |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 5 |
| 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | 6 |
| 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 7 |
| 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 7 |
| 2.12. Шилэн дансны мэдээлэл..... | 7 |
| 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт | 8 |
| 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 8 |
| 3. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан | 9 |
| 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 9 |
| 3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 10 |
| 3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 12 |
| 3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 14 |
| 3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 15 |
| 3.6 Аудит хийсэн нэмэлт орлого, санхүүжилтийн тайлан..... | 17 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| БОАЖЯ | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

᠒᠐᠒᠐.᠐᠒.᠒7 № ᠐᠖/᠖33
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2 Төсвийн тухай хуулийн 8.9.1 дүгээр зүйлд заасны дагуу “Туул голын сав газрын захиргаа”-ны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Туул голын сав газрын захиргаа”-ны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн тайлангийн журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Туул голын сав газрын захиргаа”-ны 2019 оны төсвийн гүйцэтгэл, жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл, тодруулга тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлан хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Туул голын сав газрын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, захиргааны удирдлагын албаны менежер Б. Батцэцэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Туул голын сав газрын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Туул голын сав газрын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Завсрын үеийн аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 15-наас 30-ны хооронд, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 24-нөөс 2 дугаар сарын 3-ны хооронд хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Акпар-Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Туул голын сав газрын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 02/09 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Туул голын сав газрын захиргааны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Сав газрын хэмжээнд усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой

ашиглах, нөхөн сэргээх, орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оршино.

Туул голын сав газрын захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Туул голын сав газарт усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, журмуудад томоохон өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Туул голын сав газрын захиргааны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Туул голын сав газрын захиргаа нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous 4.0” программ хангамж ашигладаг байна.

Туул голын сав газрын захиргаа нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас гүйцэтгэдэг байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Туул голын сав газрын захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 228,948.0 мянган төгрөгөөс тооцон 4,578.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 20,445.6 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Туул голын сав газрын захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 793,534.8 мянган төгрөгөөр буюу 346.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Балансын үзүүлэлт | /мянган төгрөг/ | | |
|-------------------------------|------------------|--------------------|------------------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | - | 244,939.1 | 244,939.1 |
| Урьдчилж төлсөн зардал | - | 548,800.0 | 548,800.0 |
| Бараа материал | 30,954.6 | 48,692.6 | 17,738.0 |
| Үндсэн хөрөнгө | 197,993.4 | 180,051.2 | -17,942.3 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 228,948.0 | 1,022,482.8 | 793,534.8 |
| Богино хугацаат өр төлбөр | - | 3,853.5 | 3,853.5 |
| Урт хугацаат өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо | 346.8 | 346.8 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 228,601.2 | 1,018,282.5 | 789,681.3 |
| ӨР ТӨЛБӨР / ӨМЧИЙН ДҮН | 228,948.0 | 1,022,482.8 | 793,534.8 |

Авлага дансны үлдэгдэл өссөн нь “Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир усыг биотехнологийн аргаар цэвэрлэх төсөл”-ийн санхүүжилтийн үлдэгдлийг оны эцэст Сангийн яам эргүүлэн татсанаас, урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл өссөн нь гүйцэтгэгчид олгосон урьдчилгааг хуримтлуулан бүртгэснээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь Улаанбаатар хот орчимд Туул голын дагуу, эрүүл ахуйн шаардлага хангасан зөөврийн ариун цэврийн байгууламж байгуулж байгаатай холбоотой ариун цэврийн болон ариутгал, шинжилгээний тусгай материалыг нэмж авснаас, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А-1/3285 тоот шийдвэрийн дагуу хөрөнгө акталсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь “Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир усыг биотехнологийн аргаар цэвэрлэх төсөл”-ийн гүйцэтгэлд хяналт тавихад зарцуулсан шатахууны үнийг ондоо багтаан шилжүүлж чадаагүйгээс тус тус шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд заасны дагуу Туул голын сав газрын захиргааны урсгал зардалд 363,024.2 мянган төгрөгийн төсөв баталсан ба орлогын төлөвлөгөө өгөөгүй байна.

Тайлант онд батлагдсан төсвийг 100.0 хувь олгосон ба нэмэлт орлогоор 15,500.0 мянган төгрөгийн орлого оруулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.5-д харуулав.

Төсвийн санхүүжилтээс 19,806.2 мянган төгрөгийг улсын төсөвт эргүүлэн шилжүүлж, урсгал зардлын төсвийн гүйцэтгэл 94.4 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг хэмнэлттэй зарцуулсан байна.

Нэмэлт төсөв “Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир усыг биотехнологийн аргаар цэвэрлэх төсөл”-ийн хүрээнд олгосон 800,000.0 мянган төгрөг, Дэлхийн банкнаас сургалт, семинарт зориулж олгосон 40,585.0 мянган төгрөг, БОАЖЯ-ны Байгаль орчин, уур амьсгалын сангийн “Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулах төсөл”-өөс Туул голын эргийн дагуу ариун цэврийн байгууламж барих болон цэвэрлэгээнд зориулж олгосон 16,128.4 мянган

төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлого 15,500.0 мянган төгрөг нийт 872,213.4 мянган төгрөгийн орлого орсноос 618,773.8 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 253,439.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан татсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд эрсдэл гараагүй бөгөөд нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар дараах дараах зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар “Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир усыг биотехнологийн аргаар цэвэрлэх төсөл”-ийг хэрэгжүүлж эхлэхийг даалгасны дагуу, төслийн гүйцэтгэгчээр “Ховд тул” ХХК-тай шууд 800,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Гэтэл байгууламжийн зураг, төсөвт магадлал хийлгээгүй байхад гэрээ байгуулж, ажлыг эхлүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлагыг хүргүүлэх.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

1. Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар “Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир усыг биотехнологийн аргаар цэвэрлэх төсөл” хэрэгжүүлэх шийдвэр гарч, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/360 дугаар тушаалаар Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн санхүүжилтээс 800,000.0 мянган төгрөг хуваарилжээ.

Төслийн гүйцэтгэгч “Ховд тул” ХХК-тай 2019 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр 800,000.0 мянган төгрөгийн гэрээ шууд байгуулсан байна.

Гүйцэтгэгч тал гэрээнд заасан хугацаанд ажлаа дуусгаж чадаагүй тул гэрээний хугацааг 2020 оны 6 дугаар сарын 5 хүртэл сунгаж ТТ/02 дугаар бүхий нэмэлт гэрээ байгуулсан байна.

Тус байгууламжийн ажил эхэлсний дараа Барилгын хөгжлийн төвийн 2019 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр 1908/2019 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр төсөвт өртөг 1,440,132.5 мянган төгрөг болсон байна.

Иймд энэ төслийн зураг, төсөвт өртөг, гүйцэтгэсэн ажлын дүн, байгууламж нь стандартын шаардлага хангаж байгаа эсэх асуудалд гүйцэтгэлийн аудит хийлгүүлэх саналтай байна.

1. 2019 оны 6 дугаар сарын 24-ний өдөр тус байгууллагын 2 давхрын арын цонхоор 736.7 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 3 ширхэг нөтбүүк хулгайд алдагдсан байна. Эзэн холбогдогч нь одоо хүртэл олдоогүй тул энэ асуудлыг эцэслэн шийдвэрлээгүй байна.

Эдгээр асуудлыг дараагийн аудитор анхааралдаа авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Туул голын сав газрын захиргаа Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 90 мэдээллийг хугацаанд нь, 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бөгөөд байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Туул голын сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайланд “Акпар-Аудит” компани аудит хийсэн ба зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөөгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Туул голын сав газрын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Туул голын сав газрын захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|-----------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 30,954,562.49 | 842,431,658.49 |
| 33 | АВЛАГА | - | 244,939,100.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 244,939,100.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | - | 548,800,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 548,800,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 30,954,562.49 | 48,692,558.49 |
| 351 | Түүхий эд материал | - | 1,579,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | 1,579,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 30,954,562.49 | 47,113,558.49 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,065,450.00 | 2,491,861.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 26,214,112.49 | 41,979,697.49 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,959,000.00 | 2,535,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 716,000.00 | 107,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 197,993,441.66 | 180,051,167.34 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 197,993,441.66 | 180,051,167.34 |
| 392 | Биет хөрөнгө | 197,867,716.96 | 180,009,259.16 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 155,264,075.19 | 162,771,475.19 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -37,697,328.39 | -45,491,813.03 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 86,276,144.37 | 86,276,144.37 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -85,853,446.27 | -86,151,821.23 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 299,835,260.30 | 260,054,706.53 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -230,739,493.38 | -204,557,447.85 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 37,301,156.44 | 36,464,961.44 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -26,787,968.30 | -29,626,263.26 |
| 39217 | Ном | 269,317.00 | 269,317.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 125,724.70 | 41,908.18 |
| 39301 | Програм хангамж | 1,105,266.00 | 1,105,266.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -979,541.30 | -1,063,357.82 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 228,948,004.15 | 1,022,482,825.83 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | = | 3,853,500.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 3,853,500.00 |
| 413 | Өглөг | - | 3,853,500.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 3,853,500.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 228,948,004.15 | 1,018,629,325.83 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 228,948,004.15 | 1,018,629,325.83 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 346,824.00 | 346,824.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 346,824.00 | 346,824.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 228,601,180.15 | 1,018,282,501.83 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 228,601,180.15 | 228,601,180.15 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 789,681,321.68 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 228,948,004.15 | 1,022,482,825.83 |

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 400,743,511.50 | 1,242,745,000.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 4,317,511.50 | 7,507,400.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 4,317,511.50 | 7,507,400.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,317,511.50 | 7,507,400.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,317,511.50 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 7,507,400.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 396,426,000.00 | 1,235,237,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 325,125,000.00 | 363,024,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 325,125,000.00 | 363,024,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 71,301,000.00 | 872,213,400.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,700,000.00 | 40,585,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,850,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 16,186,000.00 | 816,128,400.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 27,565,000.00 | 15,500,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 444,761,399.64 | 453,063,678.32 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 444,761,399.64 | 453,063,678.32 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 390,772,643.50 | 408,027,507.52 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 219,732,062.00 | 235,590,011.00 |
| 210101 | Үндсэн цалин | 178,644,937.00 | 178,100,114.00 |
| 210102 | Нэмэгдэл | 25,232,583.00 | 43,452,497.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,854,542.00 | 14,037,400.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 26,896,044.79 | 30,360,636.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,226,288.00 | 20,867,185.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,216,774.00 | 2,454,964.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,044,372.79 | 1,876,929.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,073,099.00 | 469,233.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,335,511.00 | 4,692,325.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 17,902,228.07 | 20,930,380.35 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,439,351.37 | 11,375,440.00 |
| 210302 | Түлш, халаалт | 8,462,876.70 | 9,554,940.35 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 55,448,178.50 | 18,005,377.85 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,765,300.00 | 2,840,338.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,763,900.00 | 7,794,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,578,314.50 | 3,870,711.85 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 35,340,664.00 | 3,500,328.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,123,800.00 | 8,530,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 68,000.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 700,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,055,800.00 | 7,830,000.00 |

| | | | |
|-------------|--|------------------------------|------------------------------|
| 2107 | Томилолт, зочны зардал | 18,867,000.00 | 11,429,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,867,000.00 | 11,429,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,621,530.00 | 2,990,928.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,370,000.00 | 532,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,485,000.00 | 1,485,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 204,930.00 | 363,528.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 148,500.00 | 221,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 115,100.00 | 151,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 298,000.00 | 236,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 43,181,800.14 | 80,191,174.32 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,189,924.00 | 39,143,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 40,991,876.14 | 41,047,674.32 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 53,988,756.14 | 45,036,170.80 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 16,212,000.00 | 12,707,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16,212,000.00 | 12,707,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 37,776,756.14 | 32,329,170.80 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 37,776,756.14 | 32,329,170.80 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>-44,017,888.14</u> | <u>789,681,321.68</u> |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | - | - |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | - |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>-44,017,888.14</u> | <u>789,681,321.68</u> |

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|------------------------------|--------------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>400,743,511.50</u> | <u>1,235,237,600.00</u> |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | - | - |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 4,317,511.50 | - |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 4,317,511.50 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,317,511.50 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,317,511.50 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 396,426,000.00 | 1,235,237,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 325,125,000.00 | 363,024,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 325,125,000.00 | 363,024,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 71,301,000.00 | 872,213,400.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,700,000.00 | 40,585,000.00 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,850,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 16,186,000.00 | 816,128,400.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 27,565,000.00 | 15,500,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>398,453,711.50</u> | <u>1,219,639,600.00</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 398,453,711.50 | 1,219,639,600.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 344,464,955.36 | 933,686,829.20 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 220,027,417.00 | 235,590,010.00 |
| 210101 | Үндсэн цалин | 165,697,875.00 | 178,100,113.00 |
| 210102 | Нэмэгдэл | 32,689,000.00 | 43,452,497.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 21,640,542.00 | 14,037,400.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 26,600,689.79 | 30,360,637.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,482,584.00 | 20,644,839.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,204,000.00 | 2,428,614.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,750,924.79 | 1,943,260.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 428,185.00 | 485,924.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,734,996.00 | 4,858,000.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 17,902,228.07 | 20,930,380.35 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,439,351.37 | 11,375,440.00 |
| 210302 | Түлш, халаалт | 8,462,876.70 | 9,554,940.35 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 47,534,970.50 | 17,572,733.85 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,287,120.00 | 3,126,046.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,881,900.00 | 7,354,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,014,994.50 | 3,810,711.85 |

| | | | |
|-------------|--|-----------------------------|------------------------------|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 27,350,956.00 | 3,281,976.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,771,196.00 | 10,490,640.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 655,396.00 | 655,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 1,839,640.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,115,800.00 | 7,996,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 19,377,000.00 | 11,429,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,561,530.00 | 568,169,928.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,310,000.00 | 565,611,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,485,000.00 | 1,485,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 204,930.00 | 363,528.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 148,500.00 | 221,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 115,100.00 | 151,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 298,000.00 | 336,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,689,924.00 | 39,143,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,689,924.00 | 39,143,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 53,988,756.14 | 285,952,770.80 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 16,212,000.00 | 12,707,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16,212,000.00 | 12,707,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 37,776,756.14 | 273,245,770.80 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 37,776,756.14 | 273,245,770.80 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>2,289,800.00</u> | <u>15,598,000.00</u> |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 2,289,800.00 | 15,598,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,289,800.00 | 15,598,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 2,289,800.00 | 15,598,000.00 |
| 225102 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/ | 2,289,800.00 | 15,598,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>-2,289,800.00</u> | <u>-15,598,000.00</u> |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|-------------------------|--|
| 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 346,824.00 | | 272,619,068.29 | 272,965,892.29 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 346,824.00 | | 272,619,068.29 | 272,965,892.29 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | | -44,017,888.14 | -44,017,888.14 |
| 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 346,824.00 | | 228,601,180.15 | 228,948,004.15 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 346,824.00 | | 228,601,180.15 | 228,948,004.15 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | | 789,681,321.68 | 789,681,321.68 |
| 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 346,824.00 | | 1,018,282,501.83 | 1,018,629,325.83 |

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|----------------|----------------|---------------|--------|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 363,024,200.00 | 363,024,200.00 | - | 100.00 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 363,024,200.00 | 363,024,200.00 | - | 100.00 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 350,317,200.00 | 330,511,029.20 | 19,806,170.80 | 94.35 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 253,592,500.00 | 235,590,010.00 | 18,002,490.00 | 92.90 |
| Үндсэн цалин | 186,132,400.00 | 178,100,113.00 | 8,032,287.00 | 95.68 |
| Нэмэгдэл | 49,851,000.00 | 43,452,497.00 | 6,398,503.00 | 87.16 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 17,609,100.00 | 14,037,400.00 | 3,571,700.00 | 79.72 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 31,699,000.00 | 30,360,637.00 | 1,338,363.00 | 95.78 |
| Тэтгэврийн даатгал | 21,555,400.00 | 20,644,839.00 | 910,561.00 | 95.78 |
| Тэтгэмжийн даатгал | 2,535,900.00 | 2,428,614.00 | 107,286.00 | 95.77 |
| ҮОМШӨ-ний даатгал | 2,028,700.00 | 1,943,260.00 | 85,440.00 | 95.79 |
| Ажилгүйдлийн даатгал | 507,100.00 | 485,924.00 | 21,176.00 | 95.82 |
| Эрүүл мэндийн даатгал | 5,071,900.00 | 4,858,000.00 | 213,900.00 | 95.78 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 20,931,400.00 | 20,930,380.35 | 1,019.65 | 100.00 |
| Гэрэл, цахилгаан | 11,376,200.00 | 11,375,440.00 | 760.00 | 99.99 |
| Түлш, халаалт | 9,555,200.00 | 9,554,940.35 | 259.65 | 100.00 |
| Хангамж, бараа материалын зардал | 15,009,300.00 | 14,704,333.85 | 304,966.15 | 97.97 |
| Бичиг хэрэг | 3,136,300.00 | 3,126,046.00 | 10,254.00 | 99.67 |
| Тээвэр, шатахуун | 5,833,000.00 | 5,821,000.00 | 12,000.00 | 99.79 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,077,200.00 | 3,810,711.85 | 266,488.15 | 93.46 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,962,800.00 | 1,946,576.00 | 16,224.00 | 99.17 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 14,456,900.00 | 14,428,640.00 | 28,260.00 | 99.80 |
| Багаж, техник, хэрэгсэл | 4,593,600.00 | 4,593,000.00 | 600.00 | 99.99 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,840,600.00 | 1,839,640.00 | 960.00 | 99.95 |
| Урсгал засвар | 8,022,700.00 | 7,996,000.00 | 26,700.00 | 99.67 |
| Томилолт, зочны зардал | 9,371,200.00 | 9,357,500.00 | 13,700.00 | 99.85 |
| Гадаад албан томилолт | - | - | - | - |
| Дотоод албан томилолт | 9,371,200.00 | 9,357,500.00 | 13,700.00 | 99.85 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,673,000.00 | 2,558,528.00 | 114,472.00 | 95.72 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,485,000.00 | 1,485,000.00 | - | 100.00 |
| Даатгалын үйлчилгээ | 385,000.00 | 363,528.00 | 21,472.00 | 94.42 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 258,500.00 | 221,700.00 | 36,800.00 | 85.76 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 198,000.00 | 151,800.00 | 46,200.00 | 76.67 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 346,500.00 | 336,500.00 | 10,000.00 | 97.11 |

| | | | | |
|--|----------------|----------------|---------------|--------|
| Бараа үйлчилгээний бусад зардал | 2,583,900.00 | 2,581,000.00 | 2,900.00 | 99.89 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,583,900.00 | 2,581,000.00 | 2,900.00 | 99.89 |
| ТАТААС | - | 19,806,170.80 | - | |
| Төрийн өмчит байгууллагад олгох татаас | - | 19,806,170.80 | 19,806,170.80 | |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 12,707,000.00 | 12,707,000.00 | - | 100.00 |
| Бусад урсгал шилжүүлэг | 12,707,000.00 | 12,707,000.00 | - | 100.00 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,707,000.00 | 12,707,000.00 | - | 100.00 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 363,024,200.00 | 363,024,200.00 | - | 100.00 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 363,024,200.00 | 363,024,200.00 | - | 100.00 |
| Улсын төсвөөс санхүүжих | 363,024,200.00 | 363,024,200.00 | - | 100.00 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | |
| ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | |
| Төсвийн байгууллага | - | - | - | |
| Төсвөөс гадуур байгууллага | - | - | - | |
| АЖИЛЛАГСАДЫН ТОО | 23 | 23 | - | 100.00 |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.00 |
| Гүйцэтгэх ажилтан | 18 | 18 | - | 100.00 |
| Үйлчлэх ажилтан | 4 | 4 | - | 100.00 |
| ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 23 | 20 | - | 86.96 |
| Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 19 | 16 | - | 84.21 |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 4 | 4 | - | 100.00 |

3.6 Аудит хийсэн нэмэлт орлого, санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|------------|-----------------------|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЛАГЫН ДҮН | | 872,213,400.00 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | | 872,213,400.00 |
| БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 618,773,800.00 |
| Хангамжийн зардал | | 2,868,400.00 |
| Тээвэр, шатахууны зардал | | 1,533,000.00 |
| Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл | | 1,335,400.00 |
| Эд хогшлын зардал | | 11,660,000.00 |
| Багаж хэрэгсэл | | 11,660,000.00 |
| Томилолтын зардал | | 2,071,500.00 |
| Дотоод албан томилолтын зардал | | 2,071,500.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал | | 565,611,400.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ | | 565,611,400.00 |
| Бараа үйлчилгээ, бусад зардал | | 36,562,500.00 |
| Хичээл сургалтын зардал | | 36,562,500.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 253,439,600.00 |
| Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 253,439,600.00 |
| Төсөвт төвлөрүүлсэн мөнгө | | 253,439,600.00 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 872,213,400.00 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | | 872,213,400.00 |
| Төрийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | | 40,585,000.00 |
| Дээд шатны төсвийн захирагчаас | | 816,128,400.00 |
| Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 15,500,000.00 |

